

Татварын Судалгааны Орчин Үеийн Хандлага

Нинжбатын Ууганбаатар, Мөнхбатын Саран

МУИС

Редакцид ирүүлсэн: 2022.03.15; Хэвлэхийг зөвшөөрсөн: 2022.06.08

Абстракт: Энэ өгүүлэлд төрийн эдийн засаг, төсвийн санхүүгийн салбар ухааны үүсэл, хөгжил болон өнөөгийн түвшний талаар үзнэ. Өгүүллийн зорилго нь тухайн салбарын онцлог шинж чанарыг тодорхойлж, орчин үеийн чиг хандлагынх нь талаар үнэлэлт, дүгнэлт хийхэд оршино. Мөн Монгол улсад татварын талаарх ойлголт хэр байгааг тогтоох зорилгоор УИХ-ийн сонгуульд өрсөлдөж буй намуудын мөрийн хөтөлбөрт татварын асуудал хэрхэн тусгагдсан тухай товч дүн шинжилгээг танилцуулна. Бидний тогтоосноор Монголын улс төрийн намуудын татварын бодлого, олон улсын чиг хандлагад нийцэхгүй байна.

Түлхүүр үгс: Татварын систем, Төрийн эдийн засаг, Төсвийн санхүү;
JEL код: H20, B20, P35

Н.Ууганбаатар, МУИС, Эдийн Засгийн Тэнхимийн Дэд. Проф., Email: uuganbaatar@num.edu.mn;
М.Саран, МУИС, Эдийн Засгийн Тэнхимийн магистрын оюутан Email: saranmunkhbat@gmail.com;
Дэлхийн Банк болон Сангийн Яамны санаачилга, санхүүжилтээр 2021 онд хийгдсэн “Монголын татварын системийн судалгаа: Өнөөгийн түвшин, хөгжүүлэх боломж, арга зам” судалгааны тайланд үндэслэсэн болно.

© Зохиогч(ид). 2022 Нээлттэй ашиглалт. Энэхүү өгүүллийг Creative Commons Attribution 4.0 (<http://creativecommons.org/licenses/by/4.0/>) олон улсын лицензийн нөхцөлийн дагуу түгээж буй бөгөөд энэ нь зохиогч(ид) болон эх сурвалжийг зохимжтой байдлаар эш татсан, Creative Commons лицензийн холбоосыг оруулсан, хийсэн өөрчлөлтөө дурдсан тохиолдолд хязгаарлалтгүйгээр ашиглах, түгээх, хуулбарлахыг зөвшөөрдөг.

Recent trends in tax research

Uuganbaatar Ninjbat, Saran Munkhbat

National University of Mongolia

Received: 2022.03.15; Accepted: 2022.06.08

Abstract: In this paper we study the origin, historical development and the current state of art of public finance. Our goal is to identify the main features of this field and evaluate the current trends. In addition, in order to investigate public understanding of taxation in Mongolia we briefly discuss inclusion of tax policies in party programmes during 1996-2020. Our finding suggests that policies suggested by the political parties in Mongolia are in contrast with the international trends.

Keywords: Tax system, Public economics; Public finance

JEL classification: H20, B20, P35 .

Ninjbat Uuganbaatar, Associate Professor, Department of Economics, National University of Mongolia, uuganbaatar@num.edu.mn; Saran Munkhbat, MA in Economics student, National University of Mongolia, saranmunkhbat@gmail.com;

© The Author(s). 2022 Open access. This article is distributed under the terms of the Creative Commons Attribution 4.0 International License (<http://creativecommons.org/licenses/by/4.0/>), which permits unrestricted use, distribution, and reproduction in any medium, provided you give appropriate credit to the original author(s) and the source, provide a link to the Creative Commons license, and indicate if changes were made.

1 Удиртгал

Энэ судалгаагаар татварын системийн талаар олон улсад хийгдсэн зарим академик судалгаануудыг тоймлон, энэ төрлийн судалгааны өнөөгийн түвшин, төрөл зүйл, чиг хандлага болон цаашид энэ чиглэлийн судалгааг хөгжүүлэх боломжит арга замуудыг тодорхойлохыг зорив. Энэ хүрээнд олон улсын академик хэвлэлд гарсан 8 эрдэм шинжилгээний өгүүлэл, 2 ном, 2 номын бүлэгтэй танилцаж дүн шинжилгээ хийв.

Татварын судалгаа болон төрийн эдийн засаг (ЭЗ), төсвийн санхүүгийн салбарын өнөөгийн түвшинд анализ хийхдээ *Google Scholar*-аас гадна, ЭЗ-ийн ухааны өнөөгийн хөгжил, чиг хандлагын талаарх ЭШ өгүүлэл хэвлэгддэг, Америкийн Эдийн Засгийн Нийгэмлэгээс эрхлэн гаргадаг *Journal of Economic Perspectives*, *Journal of Economic Literature* сэтгүүлүүд, мөн энэ чиглэлийн судалгаагаар дагнасан *Annual Review of Economics* сэтгүүл болон 20 боть хэвлэгдсэн *The New Palgrave Dictionary of Economics* зэрэг мэдээллийн санг ашиглав.

Улмаар Монголын нийгэмд татварын тухай асуудалд хэр зэрэг анхаарал хандуулдгийг тандах зорилгоор Сонгуулийн Ерөнхий Хорооны мэдээллийн сайтаас 1996-2020 оны хооронд буюу нийт 7 сонгуулийн жилийн УИХ-д өрсөлдсөн намуудын мөрийн хөтөлбөртэй танилцсан. Ихэнх сонгуулийн жилүүдэд 10-аас дээш тооны УТН өрсөлдсөн байх ба нийт 80 мөрийн хөтөлбөрөөс хайлт хийхэд ойролцоогоор 74%-д буюу 59 мөрийн хөтөлбөрт татварын тухай тусгасан байв. Намуудын олонх нь сүүлийн 2-3 сонгуулийн жилүүдэд өмнөх жилүүдийн мөрийн хөтөлбөрүүдтэй харьцуулахад хөтөлбөртөө “Татварын бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Татварын шинэчлэл” гэх мэт тусдаа бүлэг гарган нарийн тусгасан байв.

2 Татварын судалгаа өнөө үед

Сүүлийн жилүүдэд ОУ-ын хэвлэлд гарсан 10 ЭШ бүтээлтэй (2 ном, 2 номын бүлэг, 6 өгүүлэл) танилцахад төсвийн санхүү болон төрийн эдийн засгийн салбарын уламжлал, хөгжил, өнөөгийн чиг хандлагыг дараах 5 онцлогт багцалж болох нь тодорхой байна.

2.1 Эртний уламжлалтай

Төр улс үүссэн цагаас төсвийн санхүү болон татвар оршин байсан бөгөөд татварын бидэнд мэдэгдэж буй хамгийн эртний тохиолдол Эртний Египетэд буюу МЭӨ 3000-2800 үетэй холбогдоно. Үүнтэй харьцуулбал одоогоор мэдэгдэж буй хамгийн эртний зоосон мөнгө МЭӨ 650-600 үед хамаарах буюу татварын алба болон татварын систем нь төв банк болон мөнгөний системээс өнө эртнийх.¹ Өрнөдөд хамгийн анхны татварын цогц систем Ромын эзэнт гүрний үед буюу МЭ 200 онд үүссэн гэж үздэг (Smith, 2015). Ромын татварын систем нь үр ашиг муутай, алдагдал ихтэй байсан ба гол дутагдал нь татвар цуглуулагчдад (*publicani*) бүрэн эрх олгосноор тэд өөрсдийн үзэмжээр ханддаг байсан тухай Smith (2015)-д дурджээ.

Орчин цагийн эдийн засгийн ухаан 1776 онд буюу А.Смит “Үндэстнүүдийн Баялаг” бүтээлээ бичсэнээр төрсөн. Гэхдээ Смитээс өмнө Францад байгаль, тэр дундаа газрыг гол баялаг гэж үздэг байсан Физиократууд болон Англид алт мөнгийг гол баялаг хэмээн үздэг байсан Меркантилистуудын үзэл баримтлал түгээмэл байв. Харин Смитээс хойш сонгодог эдийн засгийн онол төрсөн ба тэднийхээр бол хөдөлмөр эдийн засгийн гол баялаг юм.

“Үндэстнүүдийн Баялаг” 5 боть бөгөөд сүүлийн 5-р боть нь *Of the Revenue of the Sovereign or Commonwealth* нэртэй татвар, эдийн засаг дахь төрийн оролцооны тухай дэлгэрэнгүй шинжилгээ

¹ Татвар нь нэн эртний болох тухай өөр баримтууд бас бий. Жишээ нь бидэнд олдсон хамгийн эртний бичгийн дурсгал болох Эртний Шумерийн буюу МЭӨ 3400-3000 жилийн шавар бичээс дээрх тэмдэглэл нь татвар, өр зээлийн бичиг байх өндөр магадлалтай гэнэ (Smith, 2015).

юм. Смитийн нэг гол санаа нь ‘зах зээлийн системд итгэж болно’ гэсэн бүрэн үндэслэл бөгөөд үүнийг орчин үед ‘үл үзэгдэх гарын онол’ гэнэ. Гэхдээ тэрээр эдийн засагт төрийн оролцоог үгүйсгээгүй, харин эсрэгээрээ тодорхой үйл ажиллагааг төр гүйцэтгэх нь зайлшгүй бөгөөд оновчтой гэсэн санааг дэвшүүлсэн байдаг. Түүний дэвшүүлсэн сайн татварын тухай зарчмууд гэвэл

- Пропорционал (*proportionality*),
- Тодорхой (*transparency*),
- Хялбар (*convenience*),
- Үр ашигтай (*efficiency*)

нар болой (Smith, 2015). Смитийн залгамжлагчид буюу сонгодог эдийн засагчид, тэдэн дундаас Р.Т.Мальтус, Ж.С.Милл, Д. Рикардо нар бүтээлдээ мөн л татварын тухай номлож байв. Тэднээс орчин үед тод үлдсэн нь Д.Рикардогийн “*The Principles of Political Economy and Taxation*” бүтээл ба түүний ‘урт хугацаанд төр өөрийгөө хэрхэн санхүүжүүлэх нь (татвар уу, зээл үү?) чухал биш, өнөөдрийн зээл маргаашийн татвар болно’ гэсэн санааг орчин үед ‘Рикардогийн ижил байх зарчим’ (*Ricardian equivalence*) гэдэг. Харин Ж.С.Милл нь газар эзэмших эрхээс олсон орлогоос, Р.Т.Мальтус үр тарианы импортоос татвар авахыг дэмжиж байв.

Тэдний дараа маржинал хувьсгалчид буюу шинэ сонгодог эдийн засагчдын үе гарсан ба тэдэн дундаас Шведийн К.Викселл, Э.Линдахл, Германы А. Вагнер, Английн А. Маршалл, А.Пиго, Ф.Рамсей нарын нэр төсвийн санхүүгийн онолд тодоор бичигдэн үлджээ. Тухайлбал Линдахл ‘татвар нь төрийн үйлчилгээг авч буй хэрэглэгчийн төлбөр юм’ гээд ‘төр татвараа тогтоохдоо хэрэглэгчийн маржинал ханамжийг тооцож үзэх хэрэгтэй’ гэсэн санаа дэвшүүлсэн нь орчин үед Линдахлын үнэ гэсэн ойлголтыг төрүүлжээ (Musgrave, 2018).

Харин түүний багш К. Викселл арай өөр саналтай байсан бөгөөд төлбөр төлөөгүй хүнийг гадуурхах боломжгүй гэх мэт төрийн үйлчилгээний онцлогуудыг илүү тодруулан, зарим төрлийн бүтээгдэхүүнийг төр дангаараа хариуцах нь зохистой гэсэн онол дэвшүүлсэн нь өнөөгийн Скандинавын загварын оюун санааны суурь болсон байна. 1890 онд А.Маршалл татвараас үүдэлтэй алдагдал (*deadweight loss*)-ийг судлан, татвар шилжих (*tax incidence*) тухай шинжилгээ хийсэн бол 1920 онд А.С. Пиго дам нөлөө (*externality*) гэсэн ойлголтыг томъёолон судалжээ (Musgrave, 2018). Кембриджийн алдарт математикч Ф.Рамсей эдийн засгийн салбарт 2 ажил хэвлүүлсний нэг нь татвартай холбоотой бөгөөд үүндээ татварын оновчтой систем (хувь)-ийг олох загвар боловсруулан тооцоолол хийсэн байдаг. 1927 онд хэвлүүлсэн түүний энэ ажил “оновчтой татвар” (*optimal taxation*)-ийн судалгааны эхлэл болсон (Smith, 2015). Улмаар 1959 онд АНУ-ийн Р.А.Мусграйв “*The Theory of Public Finance*” нэртэй сурах бичгээ хэвлүүлсэн нь “төсвийн санхүү” салбар ухааны орчин үеийн анхны сурах бичигт тооцогддог.

Энэ салбарын орчин үеийн түвшин, цар хүрээ болон гүнийг мэдрэхийн тулд 1985-2013 онд хэвлэгдсэн *Handbook of Public Economics*-ийг харахад хангалттай.² Тус *Handbook* нь 5 боть, 41 бүлэг хэвлэгдсэн байхад *Handbook of International Economics*, *Handbook of Development Economics* нь тус бүр 4 боть 51 бүлэг, 5 боть 74 бүлэг болон хэвлэгджээ. 1969-2020 онд нийт 52 Нобелийн Эдийн Засгийн Шагналыг 86 хүнд олгосноос 13 шагналын тухай албан ёсны тайлбар (press release) дээр татвар гэдэг үг ядаж 1 удаа гарсан (*W. Nordhaus*, 2018; *A. Deaton*, 2015; *T.J. Sargent & C.A. Sims*, 2011; *F.E. Kydland & E.C. Prescott*, 2004; *R.A. Mundell*, 1999; *J.A. Mirrlees & W. Vickrey*, 1996; *R.E. Lucas*, 1995; *J.F. Nash*, 1994; *G.S. Becker*, 1992; *M.H. Miller*, 1990; *J.M. Buchanan*, 1986; *F. Modigliani*, 1985; *L.R. Klein*, 1980) ба эднээс 8 шагналын эзэд болох *W. Nordhaus*, *P. Diamond*, *M. Scholes*, *J.A. Mirrlees*, *M.H. Miller*, *J.M. Buchanan*, *J. Meade*, *P.A.*

² Төсвийн санхүү болон төрийн эдийн засаг нь дан татварын тухай биш, харин төсвийн бусад орлого болон зарлага, төсвийн болон төрийн үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн орчин, зах зээлийн систем дэх төрийн үүрэг оролцоо зэрэг олон асуудлыг судалдаг.

Гарчиг	#Боть (volume)	#Бүлэг (chapter)
Handbook of Public Economics	5	41
Handbook of Health Economics	2	51
Handbook of International Economics	4	51
Handbook of Development Economics	5	74
Handbook of Agricultural Economics	5	74
Handbook of Regional & Urban Econ.	5	90

Хүснэгт 1. Эх сурвалж: <https://www.sciencedirect.com/>

Samuelson буюу нийт шагналтны 9.3% нь татвар түүний нөлөө, төсвийн санхүү болон төрийн эдийн засгийн талаар тусгайлан судалгаа хийсэн эрдэмтэд байв.³

2.2 Эдийн засгийн ухаан дахь хөгжил, өөрчлөлтөөс хамаарна

Guran & Oguz (2010)-ийн үзэж буйгаар төрийн эдийн засаг, төсвийн санхүү салбарын 20-р зууны хөгжил, эдийн засгийн ухааны хөгжил, чиг хандлагатай ойроос холбоотой. Тухайлбал 20-р зууны эхний хагаст эдийн засгийн ухаанд тухайн цаг үеийн дуудлагаар гарч ирсэн Кейнсийн урсгал хүчтэй байсан ба үүнийг даган эдийн засаг дахь төрийн оролцоо ч эрчимтэй нэмэгдсэн.

Энэ үед төсвийн санхүүгийн онол нь татвар болон сангийн бодлогын макро-эдийн засагт үзүүлэх нөлөөн дээр тулгуурлан судлагдсан гэнэ (Guran & Oguz, 2010). Жишээ нь энэ салбарын эцэг гэгддэг Р.А.Мусграйв 1939 онд төрийн үндсэн үүрэг оролцоог гурав салган үзэх хэрэгтэй хэмээн номложээ. Үүнд (the Musgrave three-function framework) Макро эдийн засгийг тогтворжуулах (macroeconomic stabilization), Орлогыг дахин тараах (income redistribution), Эд баялгийг хуваарилах (resource allocation) нар орно (Guran & Oguz, 2010). Энэ тохиолдолд төрийг зах зээлийн бүтэлгүйтлийг залруулагч хэмээн ойлгож байсан нь тодорхой.

Үүний дараагаар буюу 1960-аад онд энэ салбарт гарсан 3 чухал өөрчлөлт нь

1. Макро эдийн засгаас илүү микро эдийн засагтай ойртсон. Үүнд нэг талаас Макро-эдийн засаг гэсэн тусдаа салбар ухаан төрөн гарсан, нөгөө талаас татварын судалгаа нь уг мөн чанарын хувьд хэнээс, юунаас, хэр их татвар авах, татварыг эцсийн дүндээ хэн төлөх вэ? зэрэг микро эдийн засгийн асуудлуудтай холбоотой байсан нь шууд нөлөөлжээ (Guran & Oguz, 2010). Ингэснээр төрийн эдийн засаг нь орчин үед микро эдийн засгийн хэрэглээний (*applied microeconomics*) магадгүй хамгийн чухал салбар болсон гэнэ.
2. Хэсэгчилсэн тэнцвэрээс илүү ерөнхий тэнцвэрт тулгуурлах болсон. 1950-60 онд Ж.Дебру болон К.Арроу нар Л.Валрасын уламжлалыг даган ерөнхий тэнцвэрийн онолыг боловсруулсан. Харин 1920-оод оноос эхлэн Кембрижийн эдийн засагчдын хийсэн татварын нөлөө, тэр дундаа татварын шилжилтийн асуудлыг судлах аргачлал нь 1900-аад онд А.Маршаллын боловсруулсан 'тухайн тэнцвэрт шинжилгээ' (*partial equilibrium analysis*)-д суурилсан байв. Шинэ онол боловсорсноор дүр зураг өөрчлөгдөв.

³ Гэхдээ бусад шагналтнууд ч энэ салбарт судалгаа хийсэн. Жишээ нь *J.E. Stiglitz* энэ салбарын хамгийн түгээмэл сурах бичгийн нэгийг бичсэн бол *J. Tobin*-ий нэртэй 'Тобин татвар' гэсэн ойлголт бий. Харин *R. Solow* нөхдийн хамт '*The Economics of Public Finance*' гэсэн ном бичсэн, *P.R. Krugman*-ийн '*International Economics*' сурах бичигт импортын татвар болон 'хөршөө ядууруулах (*beggar thy neighbour*)' бодлогын тухай дэлгэрэнгүй шинжилгээ багтсан.

Шагналын эзэн, харьяалал	Шагналын он	Төсвийн санхүү, төрийн ЭЗ-т оруулсан гол хувьд нэмэр
<i>William D. Nordhaus, Yale Univer.</i>	2018	Economics of carbon tax; Онолын хувьд сөрөг дам нөлөөтэй бүтээгдэхүүнд татвар тогтоон бүх нийтийн сайн сайхныг нэмэх боломжтой. Энэ төрлийн татварыг 'Пигугийн татвар' гэх ба өнөө үед чухал гэгдэж буй 'нүүрсхүчлийн татвар' нь Пигугийн татвар юм. Тус татварын зохистой хувийг тогтоох ЭЗ-ийн тооцоог <i>W.D. Nordhaus</i> боловсруулсан.
<i>Peter A. Diamond, MIT</i>	2010	Optimal taxation; <i>Diamond-Mirrlees efficiency theorem</i> ; <i>Mirrlees review</i> ; Бүх нийтийн сайн сайхныг хамгийн их байлгах, мөн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө багатай татварын систем
<i>James A. Mirrlees, Univer. of Cambridge</i>	1996	(татварын багц, хувь) олох асуудлыг судалсан. 2010 онд Их Британийн татварын системийг судлан, санал зөвлөмж боловсруулах эрдэмтдийн багийг J.A. Mirrlees ахалсан.
<i>Myron Scholes, Long Term Capital Management</i>	1997	<i>Modigliani-Miller theorem</i> ; <i>Scholes-Wolfson framework</i> ; Татварын системийн бизнест үзүүлэх шууд нөлөө, тэр дундаа татвар болон компанийн зах зээлийн үнэлгээ,
<i>Merton H. Miller, Univer. of Chicago</i>	1990	санхүүгийн бүтэц хоорондын хамаарлыг судалсан. <i>M.Scholes</i> нөхдийн хамт <i>Taxes & Business Strategy</i> нэртэй энэ салбарын гол сурах бичгийг бичсэн.
<i>James M. Buchanan, George Mason Univer.</i>	1986	<i>Public choice theory</i> ; Төрийн салбарт шийдвэр гаргалтад нөлөөлдөг рент олох, парламент дах суудлын тоогоо их байлгах гэх мэт хүчин зүйлсийг тогтоосон. Зах зээл заримдаа бүтэлгүйтдэг бол төр ч мөн бүтэлгүйтдэг гэсэн онол боловсруулсан.
<i>James Meade, Univer. of Cambridge</i>	1977	<i>Meade Report</i> ; 1978 онд Их Британийн татварын системийг судлан, шинэчлэлийн санал боловсруулсан эрдэмтдийн багийг ахалсан. Тус багийн тайлан Meade report гэгдэх болсон ба хэд хэдэн шинэчлэлийн санал боловсруулсны дунд орлогоос илүү зарлага дээрээс татвар авч байхыг зөвлөсөн.
<i>Paul A. Samuelson MIT</i>	1970	<i>Bergson-Samuelson social welfare function</i> ; Нийтийн сайн сайхан нь хүн тус бүрийн ханамжаас хамаарна. Энэ хамаарал тодорхой техник нөхцөлүүдийг хангаж байвал нийтийн сайн сайхныг максимумчлах эд баялгийн хуваарилалтыг тооцож болохыг тогтоосон.

Хүснэгт 2. Төсвийн санхүү чиглэлээр судалгаа хийсэн Нобелийн ЭЗ шагналтнууд. Эх сурвалж: <https://www.nobelprize.org/>.

3. Зах зээл бүтэлгүйдэгтэй ижил, төр мөн бүтэлгүйдэг (*government failure*) тухай “*public choice theory*” хэмээх шинэ онол гарсан. 1960-аад онд Жорж Мэйсон ИС-ийн эрдэмтэд зөвхөн зах зээл биш, төр засаг ч гэсэн бүтэлгүйдэг тухай онол боловсруулсан. Тэдний үзэж буйгаар ардчилсан төр гэдэг нь эрх баригч нам бөгөөд намын гол зорилго бол урт хугацааны улс орны хөгжил гэхээс илүү эрх барих хугацаа болон улс төрийн дэмжлэгээ хамгийн их байлгахад оршино. Үүнийг дагаад засгийн газрын бодлого шийдвэрүүд зарим бүтэлгүйдлийг дагуулна.

Үүний дараагаар буюу 1990-ээд оноос энэ салбарт гарсан чухал өөрчлөлт нь эмпирик буюу өгөгдөлд суурилсан судалгаанууд олширсон. Тухайлбал 1972-74 онд тус салбарын тэргүүлэх сэтгүүлийн нэг *Journal of Public Economics*-д хэвлэгдсэн нийт ажлын 25% нь эмпирик байсан бол энэ тоо 2000-02-онд 40% болж өсжээ. Үүний цаана

- өгөгдөл олноцтой болсон,
- өгөгдөлд дүн шинжилгээ хийх микро-эконометрик арга техникүүд боловсрогдсон,
- тооцон бодох машины хүчин чадал, хэрэглээ эрс нэмэгдсэн

зэрэг хүчин зүйл нөлөөлсөн байна (Guran & Oguz, 2010). Энэ салбарын нэг чухал ололт нь татварын эдийн засагт үзүүлэх шууд нөлөөг олж тогтоох явдал юм. Ингэхдээ хэрэглэдэг гол аргачлал нь татвар эдийн засгийн бусад хэмжигдэх хүчин зүйлд хэрхэн нөлөөлж буйг тогтоох буюу тухайн хүчин зүйлийн татварын мэдрэмжийг (tax elasticity) үнэлэх. Тухайлбал Wasylenko (1997)-д тоймлосон ёсоор 1960-90 онуудад АНУ-ийн өгөгдөлд хийсэн шинжилгээнээс харвал мужийн ЭЗ-ийн хөгжлийн түлхүүр үзүүлэлт болох

- ажил эрхлэлт,
- ажлын байр болон бизнесийн өсөлт,
- дотоодын болон гаднын шууд хөрөнгө оруулалт

зэрэг хүчин зүйлс татвараас сөрөг мэдрэг болох нь тогтоогдсон байна. Wasylenko (1997)-ийн тоймлосон зарим үр дүнг дараах хүснэгтэд харуулав. Wasylenko (1997) энэ төрлийн судалгаа хийхэд тулгардаг түгээмэл хүндрэлүүдийн талаар бас дурдсан байна. Үүнд

- аль өгөгдлийг аль хувьсагчийг хэмжихэд ашиглах нь зүйтэй байх;
- төсөв болон татварын өгөгдөл дээр боловсруулалт хийхдээ юуг анхаарах;
- эконометрикийн загвар боловсруулахдаа зөвхөн татварыг дангаар нь оруулаад төсвийн зардал, төрийн үйлчилгээ зэрэг хэмжигдэхүүнийг алгасах нь зөв эсэх (*specification bias*);
- татвар нь эргээд тайлбарлаж буй хувьсагчаасаа хамаарч болох (*simultaneous equation bias*)

зэрэг оржээ. Техникийн шинжтэй сүүлийн хоёр асуудлын эхнийхийг нь шийдэх нэг арга замыг санал болгосон хэмээн [Helms, L. Jay. The effects of state and local taxes on economic growth, *The Rev. of Econ. Stat*, 1985, 67, 574-82] ажлыг онцолжээ. Харин удаах асуудлыг нь ‘орлох хувьсагч’ (*instrumental variable*) ашиглах аргаар шийддэг байна.

Эцэст нь татварын судалгаа болон ЭЗ-н ухааны хөгжил ойрхон явдгийг шинэхэн жишээг дурдъя. 2012 оны Эдийн Засгийн Нобелийн шагналт *A.E. Roth* 2002 онд “эдийн засагчид өмнө нь философичид, математикчид, бодлогын зөвлөхүүд шиг ажиллаж байсан бол одоо үед инженер шиг ажилладаг болсон (*economists as engineers*)” хэмээн тунхагласан. Нийгэмд ашигтай байхаар

Хамаарах хувьсагч	Татварын мэд-рэмжийн үнэл-гээний медиан; үнэлгээний завсар	Бизнесийн татварын мэд-рэмжийн үнэл-гээний медиан; завсар	Судалгааны ажлын тоо; өгөгдлийн төрөл
Нийт ажил эрхлэлт	-0.58; [-0.85,0]	-0.11; [0.16,0]	9; мужуудыг харьцуулсан агрегат дата
Аж үйлдвэр дэх ажил эрхлэлт	-0.1; [-1.54,0.05]		13; мужуудыг харьцуулсан агрегат дата
Хөрөнгө оруулалт	-0.6; [-1.02,0.54]	-0.2; [-0.36,-0.1]	13; мужуудыг харьцуулсан агрегат дата
Мужийн нийт үйлдвэрлэл	-0.07; [-0.88,0.27]	-0.14	13; мужуудыг харьцуулсан агрегат дата
Шинээр төрж эсвэл байршиж буй бизнес	-0.18; [-0.4,0]	-0.2; [-15.7,0.6]	21; мужуудыг харьцуулсан микро дата

Хүснэгт 3. Татвар болон ЭЗ-ийн хөгжил хоорондын хамаарлын эмпирик судалгаануудын үр дүнгийн тойм. Wasylenko (1997)-с эмхтгэв.

тоглоомын дүрэм зохиох буюу ‘механизм урлах’ салбар нь амьдралд өргөн хэрэглэгдэх болсныг үүгээр цохон тэмдэглэсэн хэрэг. Харин 2019 оны Эдийн Засгийн Нобелийн шагналт *E. Duflo* 2017 онд “эдийн засагчид зөвхөн инженер биш харин сан-техникч шиг ажиллах хэрэгтэй (*economists as plumbers*)” хэмээн уриалсан. Өөрөөр хэлбэл инженер нь тооцоо болон төлөвлөгөө гаргаад гүйцэтгэлийг хянадаг бол сан техникчийн ажил илүү бодит байдалтай ойр, системийн бүх деталь дээр ажилладаг. Үүнтэй адилаар шинэ үеийн эдийн засагчид хүмүүсийн өдөр тутмын амьдралд хутгалдан, тэдний шийдвэр гаргалтыг ажиглан, талбайн туршилт (*field experiment*) явуулах замаар шийдэл боловсруулах хэрэгтэй гэсэн санааг дэвшүүлсэн.

Сүүлийн жилүүдэд *E. Duflo*-ийн санаачилгатай уялдаатай татварын тухай хэд хэдэн судалгаа хийгджээ. Тухайлбал *D. Pomeranz* Чили улсын татварын албатай хамтран НӨАТ-ийн төлөлт татварын албаны хяналтаас хэрхэн хамаарч буйг судалсан байна. Ингэхийн тулд татварын албаны судалгааны тасагтай хамтран 100.000 ААН санамсаргүй сонгон тэдэнд аудит хийгдэх магадлалтай ААН-ээр сонгогдсон тухай захидал явуулсан байна. Захидал авсан ААН-ээс шууд хэрэглэгчид бүтээгдэхүүн нийлүүлдэг ААН-үүдийн тайлагнасан орлогын дүн эрс өссөн, харин бусад ААН-д бүтээгдэхүүн нийлүүлдэг ААН-үүдэд өөрчлөлт гараагүй байна (*Pomeranz Vile-Belda, 2019*). Судлаачид ижил төстэй хэд хэдэн талбайн туршилт явуулан НӨАТ-ийн төлөлттэй холбоотой сонирхолтой үр дүнгүүд гарган авчээ.

2.3 Салбар дундын

Hanlon & Heitzman (2010)-ийн тэмдэглэснээр татварын судалгаа нь

- эдийн засаг,
- нягтлан бодох бүртгэл,
- санхүү,
- хууль эрх зүй

гэсэн дөрвөн салбарт хамааралтай байна. Тухайлбал эдийн засагчид голлон

- татвар төлөлт,
- татварын шилжилт (ж/нь бизнесийн татварын хэдэн хувийг хэрэглэгч төлдөг вэ?),
- татварын ЭЗ-т үзүүлэх нөлөө (ж/нь хөрөнгө оруулалт болон ЭЗ-ийн өсөлтөд хэр зэрэг нөлөөлдөг вэ?)
- татварын бодлогын оновчтой байдал (ж/нь аль татварын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө бага вэ?)

зэрэг асуудлуудыг судалдаг бол санхүүчид татварыг Модиглиани-Миллерийн загварын хүрээнд авч үзэн,

- татварын компанийн үнэлгээнд үзүүлэх нөлөө,
- компанийн санхүүгийн шийдвэрт татвар нөлөөлдөг эсэх,
- компанийн хөрөнгө байршуулалтад (portfolio decision) татвар хэрхэн нөлөөлдөг

зэрэг асуудлуудыг сонирхдог байна.

Харин нягтлан бодох бүртгэл нь аж ахуйн нэгжүүдтэй илүү нягт ажиллах бөгөөд

- татварт зориулан орлогоо хэрхэн тайлагнаж буй байдал,
- татвараас бултах (tax avoidance) хандлага болон түүний үр дагаврууд,
- мэдээллийн тэгш бус байдлыг (ж/нь төр болон ААН хооронд, менежер болон эзэд хооронд үүсэх) хэмжих

зэрэг асуудлыг сонирхож, хууль эрх зүйчид нь

- татварын хуулийн орчин,
- татвараас зугтах (tax evasion) болон бултах үзэгдэл,
- татварын маргаан болон тэдний шийдвэрлэлт

зэрэг асуудлыг судалдаг гэнэ.⁴

Hanlon & Heitzman (2010) эдийн засаг, санхүүгийн салбартай хамааралтайгаар нягтлан бодох бүртгэлийн хүрээнд хийгдсэн онолын судалгааг дараах 4 хэсэгт хуваан тоймлосон байна

1. Татварын тайлангийн мэдээлэгч үүрэг: Энэ мэдээллээр дамжин татвараас өмнөх орлогын менежмент, тухайн бизнесийн өсөлт, бууралт болон дотоод болон татварт зориулсан тайлан дахь орлогын зөрөө (*book-tax differences*) зэрэг асуудлуудыг судалж болно.
2. Аж ахуйн нэгжийн татвараас бултах үзэгдэл: Татвараас бултах үзэгдлийн онолын үндэслэл (*principal-agent model, principal-agent-government model*), практик дээр хэрхэн баримтжуулж хэмжилт хийх болон татвараас бултсаны шалтгаан болон үр дагавар юу болох.

⁴ Энэ мөчид буюу 2021 оны зун АНУ-ын тэргүүн баячууд (*J. Bezos, E. Musk, W. Buffett, C. Icahn, M. Bloomberg, G. Soros*) орлогынхоо багахан хувийг татварт төлсөн тухай баримт ил болсон байна. Тэд хууль зөрчилгүй, хуулийн хүрээнд 'татвараас бултсан' гэнэ (үз: www.propublica.org).

Сэтгүүлийн нэрийн хэсэг	Тоо	53 сэтгүүлд эзлэх хувь %
<i>Tax, taxation</i>	48	83
<i>Law, legal, lawyer</i>	10	17
<i>Public finance, economics</i>	8	14
<i>Accounting</i>	2	4

Хүснэгт 4

3. Аж ахуйн нэгжийн шийдвэр гаргалтад (хөрөнгө оруулалт, хөрөнгийн бүтэц, бизнесийн зохион байгуулалт гэх мэт) татварын үзүүлэх нөлөө: Жишээ нь өр, зээл ихтэй ААН тайландаа орлогоо өсгөхийн тулд өндөр татвар төлөх шаардлагатай нүүр тулгардаг тухай олон баримт бий. Энэ нь тухайн ААН ямар төрлийн бүртгэл хөтлөх нь зохистой вэ? (*book-tax tradeoff*) гэсэн шийдвэрт шууд нөлөөлдөг. Улмаар энэ шийдвэр нь дараагийн шатны шийдвэрт буюу хөрөнгө оруулалт болон ААН-ийн санхүүжилтийн бүтцэд (*capital structure*) нөлөөлдөг ба энэ эргээд бизнесийн салбарын бүтэц, татварын системийн үр ашигтай байдалд нөлөөлдөг.
4. Татвар ба хөрөнгийн үнэлгээ (*asset pricing*): Сүүлийн 30-аад жил хувьцааны ашгаас олсон орлогын татвар, хөрөнгийн зах зээл дэх бизнесийн үнэлгээнд хэрхэн нөлөөлдөг тухай судалгаа идэвхтэй явагдаж байна. Гэхдээ энэ асуудал онолын хүрээнд бүрэн ойлгогдоогүй бөгөөд одоогийн мэдэгдэж буй гол үр дүн нь Нобелийн шагналт *M.Scholes* нөхдийн хамт бичсэн "*Taxes & Business Strategy*" сурах бичигт тусгагдсан.

Татварын талаар нягтлан бодох бүртгэлийн салбарт хийгдсэн эмпирик судалгаануудыг [Shackelford, D. & Shelvin, T., Empirical tax research in accounting, 2001, *J. Account. Econ.*, 31, 321-387] ажилд тоймлосон байна.

Tran-Nam & Tran (2011) татварын чиглэлийн судалгааны сэтгүүлүүдийн чансааг тогтоох асуудлыг хөнджээ. Ингэхдээ татварын судалгаа нь

- салбар дундын шинжтэй,
- тухайн улс орны асуудлуудад төвлөрсөн (*nation specific*)

гэсэн хоёр онцлогтой гээд эдгээр онцлогууд нь заримдаа тухайн салбарын хувьд сул тал болдог гэж анхааруулсан байна. Жишээ нь Австралийн засгийн газраас судалгааны санхүүжилтийг сайжруулах зорилгоор 2008 оноос эхлэн хэрэгжүүлсэн ЭШ сэтгүүлүүдийг А, В, С, D гэж үнэлэх оролдлогод татварын сэтгүүлүүд байх ёстойгоос доогуур эрэмбэлэгдсэний нэг шалтгаан нь энэ гэнэ. Эдгээр судлаачид *Australasian Tax Teachers Association* (АТТА)-ийн гишүүд дунд татварын сэтгүүлүүдтэй холбоотой санал асуулга явуулсан ба түүнд нь нийт 72 судлаач оролцон, татвартай шууд холбоотой 58 ЭШ сэтгүүлийн талаар үнэлгээ хийсэн.

Гарсан үр дүнгээс сонирхвол А*, А болон А/В үнэлгээтэй 23 сэтгүүлд дунд *New Zealand Journal of Taxation Law and Policy*, *ATA Journal of Legal Tax Research*, *Tax Law Review*, *Tulane Law School Annual Institute on Federal Taxation* гэх мэт (илэрхий) хууль зүйн салбарын сэтгүүл, В болон В/С үнэлгээтэй 21 сэтгүүлд дунд *Journal of Forensic Accounting: Auditing, Fraud, and Taxation* гэх мэт нягтлан бодох бүртгэлийн сэтгүүлүүд багтжээ. Tran-Nam & Tran (2011)-ийн чансаагаар эрэмбэлсэн 58 сэтгүүлийн нэрс дээр дүн шинжилгээ хийвэл татварын судалгааны салбар дундын шинж чанар тодорхой харагдаж байна.

Эцэст нь, магадгүй Онцлог 1-тэй холбоотойгоор түүхийн шинжлэх ухаанд татвартай холбоотой олон чухал үйл явдалтай таардаг. Жишээ нь Тан улсын Лушаны бослого (МЭ 756), 1215 онд Англид өрнөсөн эзэн хааны эрх мэдлийг хумин, хожим үндсэн хуульт засаг тогтохын эхлэл болсон *Magna Carta*, 1773 онд АНУ-д үүсгэн байгуулагдсан Boston Tea Party, 1789 оны Францын

хувьсгал, 1810-1830 онуудад өрнөсөн Латин Америкийн орнуудын тусгаар тогтнолын хөдөлгөөн, 1930 онд Энэтхэгт М.Гандигийн удирдсан “Давсны жагсаал” зэрэгт татварын шууд оролцоо байсан гэж түүхчид үздэг (үз: Smith, 2015; R.G. Grant et al., *The History Book: Big Ideas Simply Explained*, 2016, DK).

2.4 Тухайн улс үндэстэн болон цаг үеийн нөхцөлөөс хамаарна

Нийгмийн шударга ёсны тухай ойлголтод нийцтэй, эдийн засгийн сөрөг нөлөө багатай, удирдахад хаа хаанаа амар хялбар татварын систем олох нь татварын онолын мөнхийн (*recurrent*) сэдэв. Гэхдээ нэг талаас эдгээр хийсвэр ойлголтууд цаг хугацаа болон орон зайнаас хамаардаг ба нөгөө талаас татвар нь хувьсан өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд хэрэгждэг. Иймээс татварын судалгаа нь цаг үе болон орон зайн онцлогоос шууд хамаардаг.

Үүний эхний жишээ нь дэлхийн 2-р дайны дараа суурь нь тавигдаж, 1980-аад оноос эрч аван 1990-2010 онд хүчтэй өрнөсөн даяарчлалын давлагааны улмаас татвартай холбоотой үүссэн шинэ орчин, шинэ боломж бас сорилууд юм. Энэ хүрээнд хэдэн мянган жилийн турш улс орнуудын татварын гол эх үүсвэр болсон гаалийн албан татварт харилцан буулт хийх тухай гэрээ болох *GATT (WTO)* төрөн гарч, эдийн засгийн орчин нэг төрлийн болох буюу хөрөнгийн чөлөөт хөдөлгөөнтэй холбоотойгоор төр засгууд татварын өрсөлдөөнд (*tax competition*) орсон. Даяарчлалыг зарим судлаачид хавтгай дэлхийтэй зүйрлэсэн бол хөршөө ядууруулах бодлого (*beggar-thy-neighbour*), татварын хорго (*tax haven*), татвар экспортлох (*tax exporting*), үнээр дамжуулан татвараас булгах (*transfer pricing*) зэрэг шинэ ойлголтууд гарч ирсэн. Даяаршилтай холбоотой үүссэн шинэ нөхцөл байдалд тохируулан Мексикийн ерөнхийлөгч асан, эдийн засагч Э.Седильогийн тэргүүлсэн НҮБ-ийн комиссын 2001 онд боловсруулсан тайланд “Дэлхийн Татварын Байгууллага (*World Tax Organization*)”-тай болох санал тусгагджээ (Atkinson, 2012).⁵

Жишээ болгон татварын өрсөлдөөний тухай авч үзье. Өрсөлдөөн өрнөдөг нь онолын хувьд ч, практик дээр ч тогтоогдсон хоёр төрлийн татвар байдаг нь харьцангуй өндөр хувьтай онцгой албан татвар (*excise tax*) болон хөрөнгийн орлогын татвар (*corporate income tax*) буюу ААН-ийн татвар юм (Keen, 2018). Онцгой албан татварын хувьд тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэж буй улсын татварын орчинд хамаарах заалттай (*destination principle*) хэдий ч практик дээр хил дамнасан худалдаа (*cross border trading*) болон хууль бусаар хил нэвтрүүлэх (*smuggling*) зэргээр нийлүүлж буй орны татварын орчин (*origin principle*) үйлчилдэг. Үүний тод жишээ нь хил дамнасан худалдаанаас болоод 1990-ээд онд Канад улс АНУ-ийн татварын бодлогод уялдуулан тамхины албан татвараа бууруулсан, Англи архины татвараа улс Франц улстай хиллэдэг учраас бага байлгадаг зэрэг орно (Keen, 2018).

ААН татвараа үйл ажиллагаа явуулдаг улсдаа (*territorial basis*) биш бүртгэлтэй улсдаа төлдөг (*residence basis*) үед ААН-ийн татварын өрсөлдөөн илүү хүчтэй бөгөөд үүнтэй холбоотойгоор татварын хорго гэгдэх жижиг улсууд гаднын шууд хөрөнгө оруулалт авах замаар хурдтай өссөн байдаг. OECD орнуудын хувьд ААН-ийн татварын дээд хувь 1986 онд 47% байснаа 2007 онд 27% болж буурсан байна. Сонирхолтой нь зарим хөгжингүй оронд ААН-ийн татварын хувь буурахтай зэрэгцээд татварын орлого нэмэгдсэн бол ихэнх нь хөгжиж буй орны хувьд эсрэг дүр зураг харагдаж байна (Keen, 2018). Энэ хүрээнд

- татварын өрсөлдөөнийг тоглоомын онолын үүднээс загварчлах,
- өрсөлдөөний татварын систем дэх нөлөөг тооцох,
- өрсөлдөөн хэнд ашигтай, хэнд хор хөнөөлтэй болохыг тогтоох,
- ашиггүй өрсөлдөөний эсрэг авч болох арга механизмыг боловсруулах

⁵ Судлаачид OECD нь албан бус дэлхийн татварын албатай дүйцэх үүрэг гүйцэтгэж буйг тогтоожээ: <https://digitalcommons.law.yale.edu/yjolt/vol8/iss1/5/>

гэх мэт судалгааны нэн сонирхолтой чиглэлүүд хөгжсөн байна. Сүүлийн үеийн мэдээгээр 2021 оны зуны Их 7-ийн уулзалтад яригдсан нэг чухал тохироо нь татварын өрсөлдөөнд хязгаарлалт тавих гэрээ буюу ААН-ийн татварыг 15%-аас бууруулахгүй байх тохироо юм. 7 жил хэлэлцэж байж баталсан тус гэрээнд ААН-ээс түүний үйл ажиллагаа явуулж буй улс нь татвар авч байх тухай тусгагдсан байна.

Татвартай холбоотой энэ цагийн үеийн тулгамдсан, судалгааны өнцгөөс харвал сонирхол татам, практик өнцгөөс харвал ач холбогдолтой өөр асуудлууд гэвэл

- Дэлхийн дулаарлын эсрэг татварын аргаар тэмцэх. Жишээ нь дээр дурдагдсан 'нүүрсхүчлийн татвар' (*carbon tax*) үр дүнтэй эсэх? Энэ татварын суурь нь юу байх? Хэн төлөх? Энэ татварын эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөө зэрэг асуудлуудыг судлах (Poterba, 1993);
- Санхүүгийн гүйлгээ болон электроник худалдаанаас татвар хэрхэн авч байх (Lucas-Mas & Junquera-Varela, 2021);
- НӨАТ болон хөрөнгийн татвар (*wealth tax*). Хөгжиж буй орнуудын хувьд НӨАТ-ийн цогц системтэй болох асуудал чухал бол хөгжингүй орнуудад эд хөрөнгийн татвар тулгамдсан асуудал болж байна (Atkinson, 2012)

зэрэг болно.

Дээр хэлсэнчлэн Tran-Nam & Tran (2011)-ийн тодорхойлсноор татварын судалгааны 2 гол онцлогийн нэг нь тухайн улс үндэстний онцлогоос хамаарсан явдал. Smith (2015)-ийн үзэж буйгаар улс орнуудын татварын системүүд тодорхой түвшинд ерөнхий зүйлтэй хэдий ч, өөр хоорондоо их ялгаатай (аль татварыг юунаас хэдэн хуваар тооцож авах вэ?) бөгөөд энэ ялгаа чухам юунаас болдог вэ? гэдэг төдийлөн сайн судлагдаагүй байна.

Жишээ нь

- Ихэнх хөгжингүй орнуудад 2012 оны татварын орлогын ДНБ-д эзлэх хувь 1965 оныхтой харьцуулахад өссөн байхад АНУ-д бага зэрэг буурсан;
- Булангийн орнууд гэгдэх газрын тос экспортлогч орнуудад хүн амын орлогын татвар байхгүй;
- Данийн Вант Улсад НӨАТ нэгэн жигд 25%;
- АНУ болон Европын холбоонд гаалийн татварын орлого бусад татварын орлогын 1% орчим;
- Зарим шилжилтийн ЭЗ-т орлогын албан татвар нэгэн жигд буюу тэгш хувьтай. Жишээ нь Эстон улс 1994 онд орлогын татварыг жигд 26% болгосон, үүний дараа Литв 33%, Латви 25% дээр жигдэлсэн бол ОХУ 2001 онд 13% дээр тогтоосон

зэрэг содон баримтууд байна (Smith, 2015). Татвар нь нэг талаас тухайн улсын түүхтэй, нөгөө талаас улс төрийн орчин, нөхцөл, чиг хандлагатай нь шууд холбоотой бөгөөд цаг хугацааны туршид хувьсаж байдаг тул татварын судалгаанд эдгээр тухайлсан хүчин зүйлсийг тусгах шаардлагатай юм.

2.5 Системчлэгдсэн

Татвар нь эдийн засгийг бүхэлд нь хамарсан том систем, хэрсэн том сүлжээ учир түүнийг ойлгох, судлах, татвар дээр дүн шинжилгээ хийх нь систем дээр ажиллахыг шаардана. Үүний

хамгийн том жишээ нь 2011 онд Их Британийн *IFS (Institute for Fiscal Studies)*-ийн захиалгаар Нобелийн шагналт эдийн засагч *J.Mirrlees*-ийн ахалсан багийн Их Британийн татварын систем дээр хийсэн дүн шинжилгээ юм. Тус багт *J.Mirrlees*-ээс гадна *T. Besley, R. Blundell, G.Myles, J. Poterba* зэрэг энэ цаг үеийн тэргүүлэх эрдэмтэд орсон бөгөөд татварын системийг судлахдаа тэдний баримталсан гол зарчим нь системчлэх буюу татварын системийг нэг бүхэл хэмээн үзэх байв (Johnson & Myles, 2011). Тодруулбал тэдний санал болгож буй Их Британийн татварын системийг зохиох, сайжруулахад баримтлах гурван зарчим нь

- Системчлэх буюу татвар, халамжийн системийг нэг бүтэн болгож урлах. Систем бүхлээрээ ногоон бас шударга хуваарилалттай (progressive) байх ёстой. Харин системийн хэсэг буюу татвар бүр тийм байх албагүйн дээр боломжгүй;
- Нейтрал чанарыг эрэлхийлэх. Олигтой үндэслэлгүйгээр ижил төстэй үйл ажиллагаануудад ялгавартай ханддаг татварын систем нь хүмүүсийн шийдвэр гаргалтад нөлөөлөх замаар эдийн засгийн хувьд алдагдалтайгаас гадна татвараас бултах хандлагыг өдөөдөг;
- Аль болох үр ашигтайгаар ачааг шударга хуваах. Тухайлбал татварын суурийг хөндөн үр ашиггүйдэл үүсгэх замаар прогрессив системд хүрэхийн оронд, суурийг өргөн байлгаж татвар болон халамжийн хувь хэмжээнд зохицуулалт хийх нь зөв. Татварын хувийн шатлал гаргахдаа ажил эрхлэлт болон орлогын урсгалд үзүүлэх сөрөг нөлөөг хамгийн бага байлгах ёстой.


Тус багийн тайланг *Mirrlees Review* гэж нэрлэх болсон бөгөөд ижил төстэй судалгааг анх 1978 онд мөн л Их Британийн татварын систем дээр өөр нэг Нобелийн шагналтан *J.Meade*-ийн удирдсан баг хийж байж. *Meade review* нь *The Structure and Reform of Direct Taxation* нэртэй нэг боть хэвлэгдсэн бол *Mirrlees Review* нь *Dimensions of Tax Design* (OUP, 2010) болон *Tax by Design* (OUP, 2011) гэсэн хоёр боть хэвлэгдсэн.⁶ Мөн иймэрхүү судалгаанууд Австрали болон Шинэ Зеландын татварын систем дээр хийгдсэн байна (Atkinson, 2012).

Бидний үзэж буйгаар татварын судалгааг системчлэн хийх шаардлага дараах онцлогуудаас нь төрөн гарч байна. Үүнд

- Дээр хэлсэнчлэн татвар өөрөө нэг бүхэл систем;
- Татвар хооронд харилцан үйлчлэл буюу дам хамаарал их;
- Татварын систем урлах, системийг шинэчлэхэд гол шалгуур үзүүлэлт болох (1) Үр ашиг (*efficiency*), (2) Ачааг шударга хуваарилах (*equity*) нар нь ихэнх тохиолдолд хоорондоо нийцгүй бөгөөд татварын төрлөөс хамааран эдгээр үзүүлэлтийн биелэлт өөр өөр байдаг. Жишээ нь эдийн засагт үзүүлэх нөлөө хамгийн бага буюу хамгийн үр ашигтай гэгддэг толгойн татвар (*poll tax*) нь ачааг шударга хуваарилах тал дээр хамгийн муу, худалдааны татвар дунд онолын хувьд хамгийн үр ашигтай Рамсейн татвар нь татвар цуглуулалтын өнцгөөс хамгийн их зардалтай нь гэх мэт.

Дээр дурдсан IFS-ийн судалгаанд Их Британийн татварын систем хэр шударга вэ? гэсэн асуултад хариулахын тулд өгөгдөл бол симуляц хийх загвар ашиглан дараах тооцоог гаргажээ: орлогын татвар шударга байхыг эрхэмлэсэн өсөх (*progressive*) бүтэцтэй, харин зардлаас авах татварууд худалдан авагчийн орлогын түвшнээс бага хамаардаг тул эсрэг шинж чанартай. Эд нар нэгдэхээрээ татварын ачааг хүн амын хамгийн ядуу 20% болон баян 30% дээр голлон үүрүүлж байна (Smith, 2015).

⁶ *Dimensions of Tax Design*: https:ifs.org.ukdocsmirrlees_dimensions.pdf. *Tax by Design*: <https:ifs.org.ukdocstaxbydesign.pdf>



Зураг 1. УИХ-д өрсөлдсөн намууд болон тэдгээрээс татварын тухай тусгасан намууд

3 Улс Төрийн Намуудын Мөрийн Хөтөлбөрт Татварын Тусгагдсан Байдал

2004 оноос хойш улсын их хуралд нэр дэвшигч намын тоо өссөөр байна. УИХ-ын сонгуульд өрсөлдөж буй 10 намын дунджаар 7-гийнх нь мөрийн хөтөлбөрт татварын тухай тусгагдсан байгаа нь татвар улс төрийн хүрээнд сонирхолтой сэдэв гэдгийг харуулж байна.

Харин намуудын мөрийн хөтөлбөрт татвар хэрхэн тусгагдаж вэ? гэдэгт дараах хариултыг өгч болно. 1996-2020 оны хооронд сонгуульд нэр дэвшсэн намуудын мөрийн хөтөлбөрөөс харахад

- 37%-д нь татварыг ялгавартайгаар бууруулна,
- 15%-д нь татварыг ялгавартайгаар нэмэгдүүлнэ,
- 14%-д нь татварыг ялгавартайгаар өөрчилнө


гэж тусгасан байна.

Харин татварын тусгагдсан төрлөөр нь авч үзэхэд намуудын 39% нь мөрийн хөтөлбөртөө гаалийн татварын тухай тусгасан байна. Мөн давхардсан тоогоор намуудын 29% нь ХАОАТ, 32% нь ААНОАТ-ын талаар түлхүү тусгасан бол 20% нь НӨАТ татварын тухай баримтлах бодлогоо илэрхийлсэн байна.

4 Дүгнэлт

Германы эдийн засагч Адольф Вагнер 20-р зууны эхэнд капиталист ЭЗ хөгжихтэй зэрэгцэн төрийн секторын ДНБ-д эзлэх хувь багасах биш харин ихэсдэг гэсэн эмпирик зүй тогтол олж нээсэн нь орчин үед Вагнерын хууль (*Wagner's Law*) гэгдэх болсон. 20 зууны туршид хөгжингүй орнуудын ЭЗ-т төрийн секторын эзлэх хувь өссөн баримт ч энэ хуультай нийцтэй бөгөөд Монголын нийгэм ЭЗ-ийн цаашдын хөгжил төрийн үүрэг, оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэх болно гэж таамаглах бүрэн үндэслэлтэй. Иймээс төрийн ЭЗ, төсвийн санхүүгийн салбарыг Монгол улсад хөгжүүлэх бодит шаардлагатай тулгарч байна.

Монголын улс төрийн намууд ихэнхдээ татварыг нийгэм, ЭЗ-ийн хөгжил болон дэмжлэг авахаар зорьж буй сонгогчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчлөх санал дэвшүүлж байна. Тэд татварыг зорилго биш хэрэгсэл гэж ойлгож байгаа бөгөөд мөрийн хөтөлбөрийн 66% нь татварын



Зураг 2. Татварын тусгагдсан төрлөөр, хувийн жингээр

систем дэх ялгавартай хандалтыг ихэсгэх санал гаргаж буй нь татварын онолтой нийцэхгүй байна. Тухайлбал Бүлэг 2.5-д дурдсан *Mirrlees Review*-ийн татварын систем урлах, сайжруулахад баримтлах тулгуур гурван зарчимтай зөрчилдөж байна.

Ном зүй

- Atkinson, A. B. (2012), “The Mirrlees review and the state of public economics”, *Journal of Economic Literature*, 50(3), 770-780.
- Guran, M.C. and S. Oguz, (2010), “Kamu ekonomisi alaninda gecmisten gunumuze yasanan galismeler ve gelecege iliskin beklentiler”, *Maliye Dergisi*, 158, 75-102 [Түрк хэл дээр].
- Hanlon, M. and S. Heitzman, (2010), “A review of tax research,” *Journal of Accounting and Economics*, 50, 127-178.
- Johnson, P. and G. Myles, (2011), “The Mirrlees review”, *Fiscal Studies*, 32(3), 319-329.
- Keen, M. (2018), “Tax competition”, in Blume, L.A., Durlauf, S. eds, *The New Palgrave Dictionary of Economics*, 3rd eds., Palgrave Macmillan, 13447-57.
- Lucas-Mas, C.O. and R.F. Junquera-Varela, (2021), *Tax Theory Applied to the Digital Economy: A Proposal for a Digital Data Tax and a Global Internet Tax Agency*, World Bank, DC.
- Musgrave, R. A. (2018), “Public finance”, in Blume, L.A., Durlauf, S. eds, *The New Palgrave Dictionary of Economics*, 3rd eds., Palgrave Macmillan, 10962-73.
- Pomeranz, D. and J. Vile-Belda, (2019), “Taking state-capacity research to the field: Insights from collaborations with tax authorities”, *Annual Review of Economics*, 11, 755-81.
- Poterba, J.M. (1993), “Global warming policy: A public finance perspective”, *Journal of Economic Perspectives*, 7(4), 47-63.
- Smith, S. (2015), “Taxation: A Very Short Introduction”, OUP.
- Tran-Nam, B. and A. Tran, (2011), “Ranking tax journals - A peer perception study”, *Australian Tax Forum*, 26(2), 213-255.
- Wasylenko, M. (1997), “Taxation and economic development: The state of the economic literature”, *New England Economic Review*, 3, 37-52.